



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/3321

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, 6.1.9 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 07 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2023 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол улсын ховор амьтны жагсаалтад багтсан хүрэн баавгай иргэдийн суурьшлын бүс рүү орж ирэх тохиолдол ихсэж байгаатай холбогдуулан учирч болзошгүй эрсдэлээс хүн, амьтдыг хамгаалах, биотехникийн арга хэмжээ авах, амьтны тархац нутагтай ойр амьдарч буй иргэдийн аюулгүй байдал, учирч болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээллээр хангах, хүрэн баавгайг аюулгүй болгох үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хүрэн баавгайг аюулгүй болгох, шилжүүлэн байршуулах тохиолдолд шаардлагатай зөөвөрлөх тор, амьд баригчийг стандартын дагуу хийх, аюулгүй зөөвөрлөхөд ашиглах унтуулах үйлчилгээтэй зэвсэг, сумны судалгааг гаргаж, танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ш.Баасандорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6323010326



**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХҮРЭН БААВГАЙГ АЮУЛГҮЙ БОЛГОХ,
ИРГЭДЭД ЗӨВЛӨМЖ ЧИГЛЭЛ ӨГЧ АЖИЛЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: - Аймгийн Засаг даргын орлогч
- Гишүүд:
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
 - Мал эмнэлгийн газрын дарга
 - Эрүүл мэндийн газрын дарга
 - Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч
 - Цагдаагийн газрын Нийгмийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга
 - Тухайн сумын Засаг дарга
 - Тухайн сумын Санхүүгийн албаны дарга
- Нарийн бичгийн дарга: - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын биологийн төрөл зүйл, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүрэн баавгайг унтуулах, устгах тохиолдолд тухайн орон нутгаас галт зэвсэг эзэмших, ашиглах зохих зөвшөөрөлтэй 3 иргэнийг ажлын хэсэгт нэмэлтээр оруулна.